

# Бэсрэг уртын дуу гэж ямар дууг хэлэх вэ?



Дээд, доод өнгө нь өргөн биш цар хүрээтэй, шуранхайгүй, хэм тодорхой, хэмнэл тодорхой, уртын дууны хувьд аялгууны хувьд багавтар дууг **бэсрэг уртын дуу** гэнэ.

Жишээ нь: “Дөрвөн настай халиун”, “Шалзат баахан шарга”, “Хүрэн толгойн сүүдэр”, “Тоорой Банди” гэх мэт...

# Уртын дуу бол монгол ардын дууны сонгодог хэлбэр.

## Монгол уртын дуу

Баялаг  
хэмнэлтэй



Өргөн  
цараатай

“Хэрлэнгийн баръяа”  
Бага октавын фа- II  
октавын си бемоль



Аялгууны  
үсрэлт ихтэй

“Өвгөн шувуу” бага  
аравт буюу арван  
өрөг үсэрдэг



Хөг  
шилжилт  
элбэг

“Цэвцгэр хурдан шарга”



?



Гүн гүнзгий утга  
агуулгатай

Монгол ардын уртын дуу  
сэтгэлгээний хувьд:

Ухаарал бодрол  
шингэсэн

*“Тосонгийн оройгоор тоосроод байна  
Тогтож суухыг болилоо доо  
Мандлын оройгоор манараад байна  
Манай нутаг санагдаад байна  
Сэрвэнгийн оройгоор сэрвэлзээд байна  
Сэтгэл санаа үймрээд байна”*

# ?

Энэхүү дуунд хүний сэтгэлийн хүүрнэлийг өгүүлжээ. Өсч төрсөн нутаг орон, аав ээж элгэн саднаа санан гэгэлзсэн хүний сэтгэлийн гунихрал, тэмүүллийг тоосорсон манан, сэнсэрсэн салхитай зүйрлэн харуулжээ.

Доктор Л.Хүрэлбаатар дууны утга санаа, түүхийн талаар “Анх Жалханз хутагтын шавь, албат болж ирсэн хэсэг айл, нутаг орноо санахын эрхэнд тэр нутгийн манарч, тоосорч, сэргэлзсэн Мандал, Тосон, Сэргэнгийн уулсыг харж, уг дууг зохиож дуулсан гэдэг” хэмээжээ.

# ?

Ардын урлаг судлаач Ж.Бадраа “Хотгойд дууны ая нь бэсрэг уртын дууны шинжтэй, уртавтар богино хэмнэлтэй, гэгэлгэндүү хөг аялгатай, уянгалаг төрх нь уул хадыг цуурайтуулан дуулах гэсэн зорилготой болов уу?” хэмээн дүгнэсэн байдаг. Хотгойд дуу нь хүн байгалийн харилцан шүтэлцээг бэлгэдэх, зүйрлэх байдлаар харуулдаг. Ардын дууны аялгуу айзамд газар орон, уул усны тогтоц шууд нөлөөлдөг байна.



A photograph of a mountain range with a black line tracing the peaks. The mountains are rocky and partially covered with green trees. The sky is white.

**Сэдэв аялгууг дээрх зураглалтай харьцуулан сонсоорой.**



# ?

## ТОСОНГИЙН ОРОЙ

“Тосонгийн орой” бэсрэг уртын дууг хөгжмийн зохиолчид уран бүтээлдээ авч ашигласан байдаг. Жишээ нь:

Олон улс үндэстний ардын дууг авч бүтээл хийдэг “Энигма” хамтлаг “Age of Loneliness” (Ганцаардлын нас) дуундаа “Тосонгийн орой” бэсрэг уртын дууг new age, world music хэв маягаар найруулж Монгол хөгжмийг дэлхийд таниулахад хувь нэмрээ оруулсан юм. Мөн хөгжмийн зохиолч Х.Алтангэрэлийн уран бүтээлд ч тусгалаа олсон байдаг.

**Ad libitum**



То - сон гий нээ \_\_\_\_\_ о - рой- гоор \_\_\_\_\_ тоос - роод \_\_\_\_\_  
Тог - то- жээ \_\_\_\_\_ суу - хаа \_\_\_\_\_ боли - лоо \_\_\_\_\_

Хөгжмийн зохиолч Х.Алтангэрэл энэхүү зохиолоо уран сэтгэмжийн төрлөөр 2008 онд “Хөсөгтөн” хамтлагийн морин хуурч, хөөмэйч О.Чулуунбаатарт зориулж бичжээ. “Тосонгийн орой” нь ижил нэрт ардын дуунаас сэдэвлэн бичигдсэн бөгөөд энэ дууг хотгойд, дархад дууны нэрт мастер Д.Надмид дуулсан байдаг.

?

|                | Хэсэг 1 | Хэсэг 2 | Төгсгөл |
|----------------|---------|---------|---------|
| Хурд           |         |         |         |
| Хүчдэл         |         |         |         |
| Хөгжмийн төрөл |         |         |         |

New age – нью эйдж - шинэ эрин. Хөнгөн дуугаралттай, цахилгаан хөгжим болон угсаатны хөгжмийн зэмсэг, арга барилыг хослуулсан, удаавтар, гэгээлэг, өөдрөг аялгууг голчилдог хөгжмийн төрөл.

World music – дэлхийн хөгжим. Уламжлалт ардын хөгжим, Европын бус уламжлалт сонгодог хөгжмийн хөг эгшиглэгээ, зэмсэг, хөгжимдөх, дуулах арга барилыг ашиглан бүтээн туурвидаг орчин цагийн “барууны” хөгжмийн хэв маяг.

# Дүгнэлт

Монгол уртын дуу бол монгол ардын дууны **сонгодог хэлбэр** мөн бөгөөд **дэлхий дахинд** ардын дууны шинж төлөвтэй харьцуулан үзэхэд нэн өвөрмөц, гайхам сонин, чухам **Монголын урлал** гэж үздэг. Уртын дуу бол уудам тэнэгэр сайхан **нугалаатай**, уянга төгөлдөр олон янзын **гоёмсог эгшиг чимэгтэй**, хүний сэтгэлийг хөдөлгөн догдлуулам хөгжүүн **бадрангуй сайхан аялгуу** нь оргилон дээшилж, нарийсан нарийссаар **"шуранхайлах"**, тэгснээ доошилж нугалаа хугалаа, хоолой амьсгалын цохилт хийж, хүнгэнэн **өргөн цараатай**, сонсож ханашгүй **эгшиглэнтэй**гээр хадаадаг нь Монгол сайхан эх орны тэнэгэр **уудам тал нутаг** хийгээд, дэлгэр баян хангайн **сүрлэг өндөр уул нуруу**, даваа гүвээ, өргөн тунгалаг **гол мөрөн**, өтгөн хөвч **ой шугуй**, үзэсгэлэн төгс байгалийн тансаг сайхан бүхнийг санагдуулж, **агт морьд**ын хурдан жороо ажнай сайныг бодогдуулж, **унасан газар**, угаасан ус, **эцэг эх** элгэн садан, **үр хүүхдүүд**, үнэнч журмын амраг **хань**, **анд нөхдөө** хайрлах **эх оронч сэтгэлийг** маань ундруулам сайхан билээ.

# Гэрийн даалгавар

Дүгнэлт хэсгийн улаанаар бичсэн үгүүдийг оролцуулан уртын дууны тухай зураглал болгон бие даалт хийж ирнэ.

- Оюуны зураглал
- Үгэн зураглал
- Зурагаар....